



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/51

Хажуу шинэ-Ус

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавих, эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлан устгах, данснаас хасах зэргээр эд хөрөнгө зохицуулалт, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлыг судалж зөвлөмж, дүгнэлт гаргаж ажиллах үүрэг бүхий сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
Нарийн бичиг:	Г.Булган	(Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч)
	Н.Болор-Эрдэнэ	(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
	Э.Лайжинханд	(Архив, бичиг хэргийн эрхлэгч)
	П.Отгонжаргал	(Цэцэрлэгийн арга зүйч)
	М.Мөнхзул	(1 дүгээр багийн Их эмч)
	Г.Бадралбаяр	(Соёлын төвийн хөгжмийн багш)
	Э.Золжаргал	(Сургуулийн нийгмийн ажилтан)

2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдлөг болгон сум орон нутагт хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж ажлын тайланг хагас жил бүр орон нутгийн өмчийн газарт тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Н.Ганбат)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ний өдрийн А/62 дугаар тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Т.АРИУНАА

